

НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛАН

2014.06.16.

Улаанбаатар хот.

Иргэд байгууллагаас тус албанд гаргаж байгаа өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэх тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 205 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилгын дүрэм”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/80 дугаар тушаалаар батлагдсан “Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам”, 2013 оны А/81 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт”, 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр албан даалгавар, 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/511 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”, Улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 03/4962 дугаар албан бичгээр ирүүлсэн ажил сайжруулах болон 2013 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 2в/644 дүгээр албан бичгээр ирүүлсэн ажил эрчимжүүлэх үүрэг, тус албаны даргын 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан “Иргэд байгууллагаас Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай журам”-ыг баримтлан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гаргаж буй өргөдөл, гомдол хүсэлтийг эцэслэн шийдвэрлэх, дахин гаргуулахгүй байх, тоог цөөрүүлэхээр ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлэгч харьяа агентлагуудад хэрэгжүүлж байгаа өргөдөл гомдлын шинэчилсэн программыг нэвтрүүлснээр өргөдөл гомдлын төрөл, шийдвэрлэлтийн байдлыг ил тод болгосон нь өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг улам сайжруулж байна.

Ажлын цагаар иргэдээс өргөдөл гомдлыг 7019-7019 дугаарын нээлттэй утас, info@courtservice.mn, nshqalba@yahoo.com цахим хаяг, биечлэн болон бичгээр хүлээн авч байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 108 албан бичиг, Шийдвэр гүйцэтгэх газраас 84 албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, өргөдөл гаргагчид хариуг хуулийн хугацаанд өгсөн байна.

Тус албанд албан бичгээр 52 гомдол, 550 хүсэлт, 70197019 дугаарын утсаар 5, цахим шуудангаар 12 өргөдөл гаргасны дагуу гүйцэтгэлийн хувийн хэргийг эрх бүхий ажилтан хянаж, хариуг өгсөн.

Албаны дарга, дэд дарга нар өргөдөл гомдлоор гүйцэтгэлийн хувийн хэргийг татан хянаж, мэргэжлийн удирдлагаар ханган, шийдвэр гүйцэтгэгч нарт давхардсан тоогоор нийт 129 албан даалгавраар үүрэг өгч, биелэлтийг эргэн хянасан. Хугацаанд өгсөн үүргийг хангалтгүй биелүүлсэн 2 шийдвэр гүйцэтгэгчийг дахин үүрэгжүүлж биелэлтийг шалгасан. Өгсөн үүргийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 3.215.858.8 төгрөгийн үнийн дүнтэй 3 гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчийн эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулж, 48.610.6 төгрөгийн үнийн дүнтэй 5 гүйцэтгэх баримт бичигт эд хөрөнгө битүүмжилж, 14 гүйцэтгэх баримт бичигт 20.581.9 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, 536.279.3 төгрөгийн үнийн дүнтэй 17 гүйцэтгэх баримт бичгийг хааж дуусгавар болгосон байна.

Өргөдөл гомдолтой гүйцэтгэх баримт бичиг бүрт тогтмол хяналт тавьж, улирал бүр ШШГЕГазарт болон ШГГазарт шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх танилцуулгыг хүргүүлж байна. ШШГЕГазрын байнгын хяналтанд байдаг 42 гүйцэтгэх баримт бичгийг сар бүр, улирал бүр шалган ажилласнаар 15 гүйцэтгэх баримт бичгийн 10637.7 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, 4019277.4 төгрөгийн 6 гүйцэтгэх баримт бичгийг хааж дуусгавар болгосон байна. ШГГазрын хяналт байдаг 12 гүйцэтгэх баримт бичигт 800.0 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, 10458.4 төгрөгийн 1 гүйцэтгэх баримт бичгийг хааж дуусгавар болгосныг танилцуулсан байна

Албаны 70197019 дугаарын утсаар, лавлагаа авах талаар 25, шийдвэр гүйцэтгэгчийн утсыг тодруулах 29, эрх сэргээлгэх талаар 8, хүүхдийн тэтгэлэгийн талаар 5, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар зөвлөгөө авахаар 3 иргэдэд хариуг өгч, нэр бүхий шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаанд холбогдуулан 5 өргөдөл гомдлын дагуу холбогдох шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг өгсөн байна.

Гаргасан өргөдөл гомдлын дагуу удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй 1 шийдвэр гүйцэтгэгчид сануулах арга хэмжээ авч бөгөөд 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн даргын зөвлөлийн хурлаар 12 шийдвэр гүйцэтгэгчийн дээрх асуудлыг хэлэлцүүлснээр, 1 шийдвэр гүйцэтгэгчид сануулах сахилгын шийтгэл оногдуулж, бусад шийдвэр гүйцэтгэгч нарт протоколоор анхааруулсан.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйн талаарх гомдлын дагуу холбогдох гүйцэтгэлийн хувийн хэргийг татан хянаж, 9 шийдвэр гүйцэтгэгчид “АНХААРУУЛГА” өгч, өргөдөл гомдолд дурдсан асуудлыг дахин гаргахгүй ажиллахыг үүрэг болгосон.

Тус албанд энэ оны нэгдүгээр улиралд ирсэн 380 өргөдөл гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 177 өргөдлөөр буюу 31.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна, ирүүлсэн өргөдөл гомдлыг ангилвал 256 хүсэлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх 124 гомдол байна.

НЭГ. Ирүүлсэн гомдлыг ангилвал:

- 1.Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй удааширч байгаа талаарх төлбөр авагчийн 65 гомдол буюу 52.4 хувь
2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар төлбөр төлөгчийн 42 гомдол буюу 33.8 хувь
- 3.Албадан дуудлага худалдааны талаарх 7 гомдол буюу 5.6 хувь
- 4.Эд хөрөнгийн үнэлгээний талаарх 9 гомдол 7.3 хувь
- 5.Шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйтэй холбоотой 1 гомдол 0.9 хувь байна.

Ирсэн гомдлуудыг дүүрэг тус бүрээр харьцуулбал,

1.Баянгол дүүрэг	32	буюу	25.8	хувь
2.Сонгинохайрхан дүүрэг	16	буюу	12.9	хувь
3.Сүхбаатар дүүрэг	25	буюу	20.2	хувь
4.Баянзүрх дүүрэг	21	буюу	16.9	хувь
5.Чингэлтэй дүүрэг	19	буюу	15.3	хувь
6.Хан-Уул дүүрэг	9	буюу	7.3	хувь
7.Бусад	2	буюу	1.6	хувь

Өмнөх оны үлдэгдэл 18 гомдлыг нэгтгэн, шийдвэрлэвэл зохих 142 гомдлыг шийдвэрлэсэн байдлыг харвал:

-Гомдол гаргагчийн гомдлыг хүлээн авч, түүний дагуу шийдвэрлэсэн 20 буюу 15.3 хувь

-Гомдлыг хүлээн авах боломжгүй тухай хариу өгсөн 47 буюу 35.9 хувь

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулсан 64 буюу 48.8 хувь байна.

ХОЁР. Ирүүлсэн хүсэлтийг ангилбал:

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралттай байгаа талаарх төлбөр авагчийн 112 хүсэлт буюу 43.8 хувь

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх төлбөр төлөгчийн 117 хүсэлт буюу 45.7 хувь

-Албадан дуудлага худалдааны талаарх 19 хүсэлт буюу 7.4 хувь

-Эд хөрөнгийн үнэлгээний талаар талаарх 8 хүсэлт буюу 3.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүсэлтийг дүүргүүдээр харьцуулан харуулбал:

1.Сүхбаатар дүүрэг	45 хүсэлт буюу 17.8 хувь
2.Баянзүрх дүүрэг	37 хүсэлт буюу 14.4 хувь
3.Баянгол дүүрэг	67 буюу хүсэлт 26.1 хувь
4.Чингэлтэй дүүрэг	51 буюу хүсэлт 19.9 хувь
5.Сонгинохайрхан дүүрэг	18 буюу хүсэлт 7 хувь
6.Хан Уул дүүрэг	36 хүсэлт буюу 14 хувь
7.ХӨТЯЭХэсэг	2 хүсэлт буюу 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх оны үлдэгдэл 15 хүсэлтийг нэгтгэн, шийдвэрлэвэл зохих 271 хүсэлтийг шийдвэрлэсэн байдлыг харьцуулбал:

-Хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн 84 буюу 32.3 хувь

-Хүсэлтийг хүлээн авах боломжгүй хариу өгсөн 52 буюу 20 хувь

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулсан 124 буюу 47.7 хувийг тус тус эзэлж байна.

Төлбөр төлөгчийн гаргасан өргөдөл гомдлыг харьцуулбал,

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралттай байгаа талаарх гомдол 42, хүсэлт 117, албадан дуудлага худалдаа болон эд хөрөнгийн үнэлгээний талаар 7 гомдол, 19 хүсэлт, шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйтэй холбоотой 1 гомдлыг тус тус гаргасан байна.

Төлбөр авагчийн гаргасан өргөдөл гомдлыг харьцуулбал,

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдуулан 65 гомдол, 112 хүсэлт гаргасан байна.

Албаны хэмжээнд төлбөр төлөгч 203, төлбөр авагч 177 өргөдөл гомдлыг тус тус гаргасан байна

Өмнөх оны үлдэгдэл 33 өргөдөл гомдлыг нэгтгэн, шийдвэрлэвэл зохих 413 өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг харьцуулбал:

-Гомдол гаргагчийн гомдлыг хүлээн авч, түүний дагуу шийдвэрлэсэн 104 буюу 26.6 хувь

-Гомдлыг хүлээн авах боломжгүй тухай хариу өгсөн 99 буюу 25.3 хувь

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулсан 188 буюу 48.1 хувь байна.

Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлэгч харьяа агентлагуудад хэрэгжүүлж байгаа өргөдөл гомдлын шинэчилсэн программ www.smartcity.mn хаягаар орж өргөдөл гомдлоо хэрхэн шийдвэрлэсэнээ хянах боломжийг бүрдүүлсэн бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2014 оны 06 дугаар сарын 13-ны хооронд 380 өргөдөл бүртгэгдснийг төрлөөр ангилбал:

-1200 тусгай дугаарын утсаар гаргасан өргөдөл 5 буюу 1.32 хувь

-Засгийн газрын 11-11 төвд гаргасан өргөдөл 4 буюу 1.05 хувь

-ub1200.mn цахим хуудсаар 1 буюу 0.26 хувь

-Байгууллагад гаргасан өргөдөл 370 буюу 97.37 хувийг тус тус эзэлж байна.

Төрлөөр ангилан үзвэл:

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар 348 буюу 91.58 хувь

-Төлбөр төлөгчийн тухай 5 буюу 1.32 хувь

-Дуудлага худалдааны талаар 20 буюу 5.26 хувь

-НЗД-н хэрэгжүүлэгч агентлагуудын талаар 3 буюу 0.79 хувь

-Шүүх эрх мэдлийн байгууллагын төрийн албан хаагчийн талаар 3 буюу 0.79 хувь

-Цагдаагийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн талаар 1 буюу 0.26 хувь байна.

Нийт 358 өргөдлийг шийдвэрлэсэн байна. Үүнээс,

-Хугацаандаа шийдвэрлэсэн өргөдөл 349 буюу 91.84 хувь

-Хугацаа хэтэрсэн өргөдөл 9 буюу 2.37 хувь

-Хугацаандаа байгаа өргөдөл 22 буюу 5.79 хувийг тус тус эзэлсэн байна.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацааг тооцвол,

-Ажлын 5 хоногт шийдвэрлэсэн 137 буюу 38.27 хувь

-Ажлын 10 хоногт шийдвэрлэсэн 106 буюу 29.61 хувь

-Ажлын 15 хоногт шийдвэрлэсэн 42 буюу 11.73 хувь


-Ажлын 30 хоногт шийдвэрлэсэн 64 буюу 17.88 хувь

-Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 9 буюу 2.51 хувийг тус тус эзэлж байна.

Шийдвэрлэлтийн дундаж хурд 9 хоног 17 цаг 20 минут байна. Энэ нь өргөдлийн шийдвэрлэсэн тухай бүрт холбогдох ажилтанд өгч картыг хаалгахгүй байх, тогтоосон хугацаанд шийдвэрлэхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.


Тус албанд 2014 оны нэгдүгээр улиралд гаргасан өргөдөл гомдлын мэдээг өмнөх 3 жилийн мөн үетэй харьцуулбал:

СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН ХОЁРДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР АЛБАНД
ХАНДАН ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТОО




СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР АЛБАНД ХАНДАН ГАРГАСАН
ГОМДЛЫН ТОО

Ирүүлсэн гомдлын тоо




СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР АЛБАНД ХАНДАН ГАРГАСАН ХҮСЭЛТИЙН ТОО

Ирүүлсэн хүсэлтийн тоо



Албаны дарга, дэд дарга нар, ахлах шийдвэр гүйцэтгэгч, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн нар шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой 346 өргөдөл гомдлыг ажлын өдрүүдэд биечлэн хүлээн авч, шууд шийдвэрлэн хариу өгч ажилласан нь өргөдөл гомдлын тоо өмнөх оны мөн үеийнхээс буурахад чухал алхам болсон. Энэ хугацаанд албан дарга нийт 210 иргэдийг биечлэн хүлээн авч уулзснаас 53 иргэн , дэд дарга нар 185 иргэдийг биечлэн хүлээн авч уулзснаас 83 иргэн өргөдөл гомдлоо амаар тус тус гаргасныг шийдвэрлэсэн байна. Ахлах шийдвэр гүйцэтгэгч нар нийт 210 иргэдийг биечлэн хүлээн авч уулзан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулан,амаар гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байна. Албаны хэмжээнд 346 өргөдөл гомдлыг амаар гаргасныг шийдвэрлэсэн байна.Графикаар харуулбал:



Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудтай харьцах харьцаанд үл ойлголцох байдал үүссэн, төрийн албан хаагчийн ёс зүйн журмыг баримтлаагүй, хувь хүний онцлог, шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаарх төлбөр төлөгчийн ойлголт байдлаас шалтгаалан гомдол гаргах нь дийлэнх хувийг эзэлж байгаа ч гэсэн дараах тохиолдолд өргөдлийг гаргаж байна Үүнд:

-Хийгдвэл зохих шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулаагүй, дутуу явуулсан

-Холбогдох газруудад лавлагааг хүргүүлээгүй, хугацаа алдан хүргүүлсэн

-Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөөгүй, үйлчилгээний стандартын дагуу иргэдтэй харьцаагүй

-Албаны дүрэмт хувцсыг зохих журмын дагуу өмсөөгүй, ажиллагааны явцад зөв боловсон хувцаслаагүй

-Шийдвэр гүйцэтгэгч утсаа авдаггүй, явуулж байгаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулаагүй, эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгдөггүй

-Шийдвэр гүйцэтгэгч удаа дараа солигдсон

-Төлбөр төлөгч хорих ял эдэлж байгаа болон орлогын эс үүсвэргүй, тогтмол орлогогүй

Өргөдөл гомдол гаргагчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх ойлголт байхгүй, зөвхөн төлбөрийг авснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг, бусад тохиолдолд явагдахгүй байна гэж үзэх хандлага их байгаагаас гомдол гаргаж байна. Төлбөрийн чадваргүй, хорих ял эдэлж байгаа, оршин суугаа газрын хаяг тодорхойгүйн улмаас төлбөр төлөгдөхгүй байгаа боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа талаарх мэдээллийг төлбөр авагч нарт өгдөг механизмыг бий болгох нь төлбөр авагч нарын зүгээс гаргах гомдлыг багасгах боломжтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, төлбөр авагч гомдол гаргасны дараа шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тайлбарлах бус тэдэнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх зөв ойлголтыг өгснөөр төлбөр авагчийн зүгээс гаргах гомдлыг багасгах боломжтой байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ДЭСЛЭГЧ

Ц.ЦОЛМОНТУЯА

ХЯНАСАН: ДЭД ДАРГА, ХОШУУЧ

Ж.НАНДИНТУУЛ

ТАНИЛЦСАН: ДАРГА, ХУРАНДАА

Э.БАТБАЯР